



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2022 оны 09 сарын 21 өдөр

Дугаар 451

Улаанбаатар хот

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг бүртгэх тухай¹

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.6, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн 21 дүгээр тогтоолоор баталсан “Зээлийн хүүг бууруулах стратеги”-ийн хэрэгжүүлэх дэд арга хэмжээний 1.4.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “ҮЦСК актив дөрөв” ХХК-ийн гаргаж буй 100,000 (нэг зуун мянга) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий, 8 хүртэл жилийн хугацаатай, уул уурхайн бус экспорт болон жижиг, дунд үйлдвэрийн зээлээр баталгаажсан нийт 1,118,103 (нэг сая нэг зуун арван найман мянга нэг зуун гурав) ширхэг хүртэлх баталгаат үнэт цаасыг энэ тогтоолын нэгдүгээр хавсралтын дагуу бүртгэхийг Үнэт цаасны газар (Б.Дөлгөөн), төвлөрсөн хадгаламжид бүртгэхийг “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК (Ш.Лхагва)-д тус тус үүрэг болгосугай.

2. Баталгаат үнэт цаасыг энэ тогтоолын 1-д заасан нөхцөлөөр үнэт цаас гаргагчид ирүүлсэн хөрөнгө оруулагчдын захиалгын гэрээний дагуу худалдахыг “ҮЦСК актив дөрөв” ХХК (Ч.Норовдэлгэр)-д зөвшөөрсүгэй.

3. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг “ҮЦСК актив дөрөв” ХХК (Ч.Норовдэлгэр)-д үүрэг болгосугай:

1/Санхүүгийн зохицуулах хороо нь энэ тогтоолын 1-д заасан баталгаат үнэт цаасыг бүртгэсэн нь тухайн үнэт цаас болон түүнийг баталгаажуулж буй зээлийн багц дахь мэдээлэл, барьцаа хөрөнгийн үнэлгээ, холбогдох бусад мэдээлэл нь үнэн зөв, эрсдэлгүй гэсэн баталгаа биш бөгөөд хэрэв тухайн баталгаат үнэт цаасанд эрсдэл үүсвэл Санхүүгийн зохицуулах хороо хариуцахгүй болохыг мэдэгдэхийн хамт энэ талаар үнэт цаасны танилцуулгад тусгайлан тэмдэглэж хөрөнгө оруулагчдад мэдээлэх;

2/Энэ тогтоолын 1-д заасан баталгаат үнэт цаасыг бүртгэсэнтэй холбогдуулан уг үнэт цаасыг баталгаажуулж буй хөрөнгийн багц дахь үл хөдлөх хөрөнгийг Хууль зүйн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2013 оны 7 дугаар сарын 25-ны өдрийн А/167/203 дугаар хамтарсан тушаалаар баталсан “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны хөрөнгийн багцыг тусгай тэмдэглэл хийх, бүртгэх тухай журам”-д заасны дагуу үл хөдлөх хөрөнгийн бүртгэлийн байгууллага дахь барьцааны бүртгэлд бүртгүүлж, энэ талаар 4 сарын дотор Санхүүгийн зохицуулах хороонд эргэж мэдэгдэх;

3/Баталгаат үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны тайланг 30 хоногийн дотор Санхүүгийн зохицуулах хороонд ирүүлж, хөрөнгө оруулагчдын өмнө хүлээсэн төлбөр төлөх, мэдээллээр хангах болон бусад үүргээ хугацаанд нь бүрэн биелүүлж ажиллах.

4.Энэ тогтоолын 1-д заасан хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг бүртгэсэнтэй холбогдуулан дараах арга хэмжээг цаашид хэрэгжүүлж ажиллахыг “Үнэт цаас санхүүжилтийн корпораци” ХХК (М.Энхтөр)-д үүрэг болгосугай:

1/Баталгаат үнэт цаасаар баталгаажсан зээлийн багцад буй зээлдэгчийг амь насны болон эд хөрөнгийн даатгалд бүрэн хамруулж ажиллах;

2/Санхүүгийн зохицуулах хороонд шаардлагатай холбогдох мэдээ, мэдээллийг тухай бүр гаргаж ирүүлэх;

3/Анх бүртгүүлсэн барьцаа хөрөнгийн үнэлгээний нийлбэр дүн, хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасны урт хугацаатай өглөгийн дүн, үндсэн болон хүүгийн төлбөр төлөлтийн талаарх мэдээллийг сар бүр тогтмол Санхүүгийн зохицуулах хороонд ирүүлж байх.

5.Энэ тогтоолын 2-т заасан гэрээний дагуу үнэт цаас худалдан авсан хөрөнгө оруулагчдын үнэт цаасны өмчлөх эрхийг баталгаажуулан бүртгэх, бүртгэлийн талаарх мэдээллийг улирал бүр гарган ирүүлж ажиллахыг “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК (Ш.Лхагва)-д үүрэг болгосугай.

6.Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан Монголбанк (Б.Лхагвасүрэн)-д дараах арга хэмжээ авч ажиллахыг зөвлөсүгэй:


1/Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуульд заасны дагуу анхны үүрэг гүйцэтгүүлэгч болон үйлчилгээ үзүүлэгч банкинд Банкны тухай хууль болон холбогдох бусад хууль, журамд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд тогтмол хяналт тавьж ажиллах;

2/Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны танилцуулгад тусгагдсан хөрөнгийн багцын шинж чанарыг судлан үзэж, эрсдэлээ тооцсоны үндсэн дээр үнэт цаасыг худалдан авах;

3/Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны санхүүжилтийн эх үүсвэрийн зориулалт, ашиглалт, эргэн төлөлтөд тавьж буй хяналт шалгалтын тайлан, мэдээг Санхүүгийн зохицуулах хороонд ирүүлэх.

7.Энэ тогтоолын 1-д заасан баталгаат үнэт цаасыг баталгаажуулж зээлийн багц дахь мэдээлэл, барьцаа хөрөнгийн үнэлгээ болон холбогдох бусад мэдээлэл нь үнэн зөв эсэхийг үнэт цаас гаргагч “ҮЦСК актив дөрөв” ХХК (Ч.Норовдэлгэр), хөрөнгө итгэмжлэн удирдагч “Үнэт цаас санхүүжилтийн корпораци” ХХК (М.Энхтөр)-д болон энэ тогтоолын хоёрдугаар хавсралтад дурдсан анхны үүрэг гүйцэтгүүлэгч 7 арилжааны банк хариуцахыг дурдсугай.

8.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба (Т.Жамбаажамц)-нд даалгасугай.

ДАРГА  Д.БАЯРСАЙХАН

Санхүүгийн зохицуулах хорооны
2022 оны 09 дүгээр сарын 21-ний өдрийн
451 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралт



“ҮЦСК актив дөрөв” ХХК-ийн гаргаж буй уул уурхайн бус экспорт болон жижиг,
дунд үйлдвэрийн зээлээр баталгаажсан баталгаат үнэт цаас

Баталгаат үнэт цаас	Нэрлэсэн үнэ /төгрөгөөр/	Тоо ширхэг	Жилийн хүү	Хугацаа	Нийт хэмжээ /төгрөгөөр/	Эзлэх хувь
Давуу эрхтэй баталгаат үнэт цаас	100,000	1,006,291	9.0%	8 жил хүртэл	100,629,100,000	90.0%
Энгийн баталгаат үнэт цаас	100,000	111,812	9.0%	8 жил хүртэл	11,181,200,000	10.0%
Нийт	100,000	1,118,103	-	-	111,810,300,000	100.0%

Санхүүгийн зохицуулах хорооны
2022 оны 09 дүгээр сарын 21-ний өдрийн
451 дүгээр тогтоолын хоёрдугаар хавсралт



“ҮЦСК актив дөрөв” ХХК-д уул уурхайн бус экспорт болон
жижиг, дунд үйлдвэрийн зээл багцлан худалдаж
буй анхны үүрэг гүйцэтгүүлэгч

№	Анхны үүрэг гүйцэтгүүлэгч	Зээлийн багц хөрөнгө (төгрөг)	Зээлийн дансдын тоо	Нийт зээлийн багцад эзлэх хувь хэмжээ
1	“Богд банк” ХК	1,802,309,986.18	7	1.61
2	“Голомт банк” ХХК	42,359,147,387.10	125	37.88
3	“Капитрон банк” ХХК	19,956,288,499.77	50	17.85
4	“Төрийн банк” ХХК	3,169,324,765.30	3	2.83
5	“Тээвэр хөгжлийн банк” ХХК	3,000,000,000.00	1	2.68
6	“Хаан банк” ХХК	35,569,929,659.74	110	31.81
7	“Хас банк” ХХК	5,953,544,878.21	29	5.32
Нийт		111,810,545,176.30	325	100.00